



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 он

ТОВЪЁОГ

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилт 2-6
- 1.2 Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн8-11

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

/Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрэм НИТХ-ын 2014 оны 103 дугаар тогтоол/

2.1. Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ зорилтын хүрээнд хийсэн ажил12-14

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ зорилтын хүрээнд хийсэн ажил14-16

2.3. Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна зорилтын хүрээнд хийсэн ажил16-18.

2.4. Төв нь үндсэн зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана зорилтын хүрээнд хийсэн ажил18-20

2.5. Суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг сургалтын явцад анги дэвших, төгсөхөд нь дүгнэх болон сурлагын амжилтын хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлалтай байна зорилтын хүрээнд хийсэн ажил20

2.6. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна зорилтын хүрээнд хийсэн ажил20-22

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

3.1.Төсөв, санхүүгийн чиглэлээр.....

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр.....

3.3. Архив, албан хэрэг, хөтлөлтийн чиглэлээр.....

3.4.Ил тод байдлын чиглэлээр.....

3.5. Хүний нөөцийн чиглэлээр.....

3.5.1.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах

3.5.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах..... 23-28

ДҮГНЭЛТ..... 29

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

1.1.1 “Ковид 19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах анги, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.

- Шинэ төрлийн коронавируст халдвар Ковид-19 цар тахлын дэгдэлт, тархалттай холбогдуулан гарсан МУЗГ-ын тогтоол, УОК, НОК, Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүдийн биелэлтийг хангах ажлын хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед ажиллах тусгай төлөвлөгөө боловсруулан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж гүйцэтгэлийг ханган мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүнийг үүрэгжүүлж ажиллаа.

1.1.2. /2.3.1.1/ Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.

“Урлантай аялъя” багш хөгжлийн аян зохион байгуулж багш нарыг үндсэн 6-н багт хувааж, баг тус бүр хийх ажлын төлөвлөгөө гаргаж шинэ санаа танин мэдэхүйн контэнт – шинэлэг цахим сургалтуудыг зохион байгуулж ажиллаа.

1-р ажил - Музей, галерейн аялал

1-р баг Богд хааны ордон музей, 2-р баг Монголын үндэсний музей, 3-р баг Монголыг уран зургийн галерей, 4-р баг “В Contemporary арт галерей” керамик артист Л.Очирсүхийн “Охь” нэртэй үзэсгэлэн, 6-р баг Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейг тус тус үзэж танилцан судалгаа хийсэн.

2-р ажил - Баг, хамт олноороо мэргэжлийн багш уран бүтээлчидээс сургалт авч лекц уншуулсан.

1-р баг Зүүн хүрээ хийдийн бурханч лам н.Эрдэмбилэг “Бурхны шашин, урлал” гэсэн сэдвээр, 2-р баг. МУБИС-ийн дүрслэх урлагийн доктор профессор М.Моломжамц “Байгуулага хамт олны эерэг уур амьсгал” сэдвээр, 3-р баг. “Хандлагаар анагаахуй” ОУ-ын байгууллагын Монгол дахь салбарын тэргүүн, “Азжаргалын боловсрол” ТББ-ын тэргүүн Д.Өлзийсайхан “Харицааны сэтгэл зүй” сэдвээр, багш 4-р баг. Урлаг, уламжлал судлаач, магистр, зураач багш Б. Эрдэнэбаяр “Өөрийгөө танихуй” дотоод мэдрэхүйн мэдлэг, танин мэдэхүйн сэдвээр,. 5-р баг. “Морьтон” галерейн арт куратор Д.Төмөрсүх “Уран Бүтээлийн эдийн засгийн эргэлт, оюуны өмч болон арт зах зээл” сэдвээр, 6-р баг Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейг “Мутарлагаар өөрийгөө илэрхийлэх нь” сэдвүүдээр албан хаагчдын дунд сургалт явууллаа.

3-р ажил - Баг бүр өөрсдийн үзэж, судалсан галерей, музейн товч танилцуулга, онцлох бүтээлүүд, урлагийн төрөл гэх мэт тодорхой сэдвүүдээр presentation бэлдэж төвийнхөө багш сурагчид ажилтан албан хаагчиддаа мэдээлэл хүргэж ажиллаа.



1.1.3. /2.6.4.1/ Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжинэ

- "ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ" уриан дор олон улс болон улс Нийслэлийн хүрээнд үндэсний бичиг соёл, өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчлан таниулах олон талт ажлуудыг зохион байгуулна.

Монгол Улсын Соёлын яамнаас зохион байгуулсан "Соёлын бүтээлч сар аян"-ы хүрээнд Монголын Хүүхдийн урлан бүтээх төв "МОНГОЛ ТУУРГАТНЫ ӨВ СОЁЛ-2022 Олон улсын хүүхдийн дүрслэх урлагийн наадмыг 2 дахь жилдээ хамтран зохион байгууллаа.

Монгол туургатны өв соёл-2022 наадам"-ын үзэсгэлэнгийн нээлт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 14:00 цагт МХУБТ-ийн "Орд арт" галлерейд зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнгийн нээлтэд Нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөө, Соёлын Яамны уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн нар ирж наадамд оролцогч хүүхдүүдэд баяр хүргэж, шагналыг гардууллаа.

Уралдаанд Монгол, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад, Халимаг улсын нийт 758 хүүхэд багачууд удирдамжид заасан гар урлал, уран зураг, монгол уран бичлэгийн төрлүүдээс сонгон "Монгол туургатны өв соёл" сэдвийн хүрээнд уран бүтээлээ туурвин ирүүлж, оролцлоо.



МУ-ын Ерөнхийлөгчийн тамгийн газар, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв, "Бичиг соёл" боловсролын төвийн хамтран зохион байгууллаа.

Үзэсгэлэнд дотоодын уран бүтээлч, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдаас гадна ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, Бүгд Найрамдах Халимаг Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны уран бичээчид бүтээлээ ирүүлжээ. Нийт 331 бүтээл ирсэн



Байгууллагаараа “Монгол бичигтэн” болох хөдөлгөөн өрнүүлж 7 хоног бүрийн 5 дах өдөр буюу Баасан гаригт нийт албан хаагчид Монгол бичгийн дугуйланд суралцаж өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлж байна.



1.2 ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Шалтгаан
1	2	3	4	5	6
Салбар чиглэл: 1					
1.а. Монгол Улсын хууль					
	9, 27.1, 31	Төрийн албаны тухай хууль	Төрийн албаны зарчмыг баримтлан хууль тогтоомжид заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	100-	-
	16.5	Төсвийн тухай хууль	2022 онд нийт 789,406,406.00 төгрөгийн орлогоос 648,911,500.00 төгрөгийн зарцуулалт хийгдэж 146,793,205.00 төгрөгийн үлдэгдэлтэй өглөг авлагагүй ажиллаж байна.	80	-
	6, 7	Шилэн дансны тухай хууль	Хуулиар тогтоосон хугацаанд https://shilendans.gov.mn/org/4315 сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.	100-	-
	5	Хөдөлмөрийн тухай хууль	Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр ханган ажиллаж байна.	100	-
	6	Хүүхэд хамгааллын тухай хууль	Хуульд заасны дагуу “Хүүхэд хамгааллын төлөвлөгөө” гарган мөрдөж ажиллаж байна.	100-	-
	7, 8, 9	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	http://huuhdiinurlan.ub.gov.mn/ сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100-	-
	7, 12, 13, 14, 15, 16	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэж байна.	100	
1.б. Улсын их хурлын тогтоол					
51	1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан “Авлигын тухай ойлголт” сургалтанд төвийн 10 багш, албан хаагчид хамрагдлаа.	-	-

1	2	3	4	5	6
03/7 98	2	Авлигын эсрэг үндэсний чуулган 2021- с гарсан зөвлөмж 2022-02-24	<p>1. Төвийн багш, албан хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно.</p> <p>2. Төвийн багш, албан хаагчдад авлига, ашиг сонирхлын талаар анхан шатны мэдлэг олгох “Авлигын тухай ойлголт” сургалтыг зохион байгууллаа.</p> <p>3. Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах утсыг тогтмол ажиллуулж байна. Ямар нэгэн мэдээлэл ирээгүй болно.</p> <p>4. Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг төвийн цахим хуудас болон фэйсбүүк хуудаст тогтмол мэдээлж байна.</p> <p>5. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу http://shilendans.gov.mn/org/4315 сайтад байгууллагын төсөв, гүйцэтгэлийн мэдээг тогтмол оруулж байна.</p>		
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
58		МУ-ын ерөнхийлөгчийн 2021 оны 58-р зарлиг “Тэр бум” мод тарих аянд нэгдэх	Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв 2022 оны 05 дугаар сарын 15-ний өдөр Хан Уул Дүүргийн 14 дүгээр хороо Айдсын Ам талбайд 43 албан хаагч хүн тус бүр 2 ширхэг нийт 86 ширхэг улиас мод тарилаа.	100	-
159		Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 159	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлигийн дагуу 2022 оны 09сарын 15 нд Эзэн Богд Чингис хааны хөргийг төдийн хүндэтгэлийн буланд залсан.	100	
1.е. Засгийн газрын тогтоол					
226		МУЗГ-ын 2021 оны 226-р тогтоол	“Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасхийлгэх, хэрэглэх журм”-ын 5.19-д хэвлэмэл хуудасны эх загварыг архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчаар хянуулж, зөвшөөрөл авсан байна гэсний дагуу байгууллагынхаа албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж буй хэвлэмэл хуудасны нэр төрөл тус бүрээс 1 ширхэг эх хувийг 2022.02.22-ны өдөр НАГ-т албан бичгээр болон цаасаар хүргүүлэн ажилласан.	100-	-

9		МУЗГ-ын 2020 оны 9-р тогтоол Өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод хамрагдах	Байгууллагын эзэмшил, ашиглалтад буй эд хөрөнгөд холбогдох журам, зааврын дагуу үзлэг, тооллого хийж, эд хөрөнгө тус бүрийг цахимд шивж оруулан дүн, тайланг 2022 оны 06-р сард илгээж ажилласан.	100-	-
338	5	МУЗГ-ын 2021 оны 338-р тогтоол Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх	МУЗГ-ын 2021 оны 338-р тогтоолын 5 дахь хэсэгт 4 чиглэлийг хүрээнд хэмнэлт гаргаж ажиллах гэж заасны сацуу хэмнэлтийн горимд шилжин хэрэгжүүлэн ажиллаж байна.	100-	-
1.ж. Нийслэлийн засаг даргын захирамж болон албан даалгавар					
A/334		НЗД-ын 2017 оны А/334-р захирамж Хуваарь чиглэл хүргүүлэх тухай / НЗД бөгөөд УБ хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнгийн мэдээллийг дараагийн шуурхай зөвлөгөөний өмнөх 7 хоногт байршуулах/	НЗД бөгөөд УБ хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнгийн мэдээллийг дараагийн шуурхай зөвлөгөөний өмнөх 7 хоногийн “Пүрэв” гарагт багтаан “Ulaanbaatar” сайтад байршуулан ажилласан.	100	-
A/452		НЗД-ын 2013 оны А/452-р захирамж	2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримт бичгээ цахим хэлбэрт шилжүүлэн байгууллагын архивын “Архив eDoc” системд хөрвүүлж нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэж, системд хөрвүүлсэн захирамжлалын баримт бичгийн цахим хувийг тусгай тээгч дээр хуулан НАГ-т товлосон хугацаанд хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан.	100	-
A/578		Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай 2022-05-01	Нийслэлийн Засаг Даргын 2022.04.27-ний өдрийн А/578 дугаар захирамжийн дагуу ажлын цаг бүртгэх төхөөрөмж болон бусад эх үүсвэр дээрхи хүний биеийн давхцахгүй өгөгдөлийг устгасан.	100-	-
A/657		НЗД-ын 2022 оны А/657-р захирамж Хуулийн хэрэгжилтийг хангах	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган тус төвийн Дэд захирал ажлаас чөлөөлөгдсөн болно.	100	

1.и. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол					
1	2	3	4	5	6
119	1.2. 2, 1.3. 1, 1.3. 2, 1.3. 3, 1.3. 4, 1.3. 5	“Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	<ul style="list-style-type: none"> Хамтын ажиллагааны хүрээнд “Хурд Интернэшнл” ХХК-аар төвийн автомашины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний 3 тусгай зогсоолыг шинээр бий болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг ханган ажиллаж байна. 	100	-
		2018-07-09 2018_119	<ul style="list-style-type: none"> Мөн хурд сааруулагч болон явган хүний гарцыг зам талбайн стандартад нийцүүлэн шинэчлэн тохижуулж, хүүхдийн аюулгүй байдалд онцгой анхааран ажиллаж байна. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Угтах үдэх үйлчилгээний журам”-ыг шинэчлэн баталж, бага насны хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийн гарт хүлээлгэн өгөх, авах зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл болон мэргэжлийн байгууллагын тавьсан шаардлага, сануулгыг суралцагч хүүхдүүдэд тухай бүр уламжилж, мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна. 	100	
65		“НИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 65-р тогтоол Журмын дагуу гэрээ байгуулж Нийслэлийн өмчийн харилцааны газарт орлого төвлөрүүлэх	022.03.14-ний өдөр Нийслэлийн өмчит хуулийн эдгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, тайлбай хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулан түүнийхээ дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газарт орлого төвлөрүүлэн ажиллаж байна.	80-	-
Нийслэлийн Онцгой Комиссоос гаргасан шийдвэрийн биелэлт					
		НОК-ын 2022.01.05-ны өдрийн албан бичиг Түр зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай	Нийслэлийн Онцгой комисс 2022 оны 01 дүгээр сарын 05-ний өдрийн №07 тоот Коронавируст халдвар /Ковид-19/ батлагдсан тохиолдлын тоо нэмэгдэж, тархах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар илэрсэн үед авах	100	

			арга хэмжээний түр зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон зохион байгуулан ажиллаж байна.		
		НОК-ын 2022.01.10-ны 01-р хурлын тэмдэглэл Цахимаар ажиллуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах	НОК-оос ирүүлсэн үүрэг чиглэлийг танилцуулж албан хаагчдыг хуваарьт оруулж цахимаар ажиллуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.	100	
		НОК-ын 2022.01.20-ны 02-р хурлын тэмдэглэл МУЗГ-ын 03-р хуралдааны тэмдэглэл, НОК-ын 01-р хурлаас өгсөн үүргийн биелэлтийг ирүүлэх	Цахимаар ажиллаж байгаа албан хаагчдын мэдэээлийг nok@ulaanbaatar.mn хаяг руу 2022.01.20-ны өдөр илгээж ажиллаа.	100	

**ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

/ Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрэм НИТХ-ын 2014 оны 103 дугаар тогтоол/

2.1. Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ”

2.1.1 2022-2023 оны хичээлийн жилд дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр хүүхэд багачуудын авьяас чадвар, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, амьдралын арга ухаанд сургаж, хөдөлмөр гоо зүйн хүмүүжил, мэргэжлийн чиг баримжаа олгоно.

- 2022-2023 оны хичээлийн жилд 18 төрлийн 20 дугуйланд 2000 хүүхэд багачууд хичээллэж байна.



2.1.2 Хүүхдийн хөгжлийг дэмжсэн соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд багачуудыг идэвхтэй хамруулна.

“Соёл урлаг, хэвлэл мэдээллийн төслийн менежмент, зөвлөгөө” НҮТББ болон ХБНГУ дахь Соёлын Элч О.Оюунтуяагийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Үлгэр домог, өв соёл төсөл”-ийн “Үлгэрийн урлан “ хөтөлбөрийг хамтран хэрэгжүүллээ. Тус төслийн хүрээнд төвийн дугуйлангуудад суралцдаг 200 сурагч 5 төрлийн сургалтанд 10 ээлжээр хичээллэн хамтарсан бүтээл туурвисан.

Үлгэрийн урлан хөтөлбөрийн сургалтын төрлүүд:

№	Сургалтын нэр	Сар өдөр	Сурагчийн тоо	Хариуцсан багш		Сонгосон үлгэр
				НҮТББ	МХУБТ	
1	Монгол зураг	2022.10.05	40	О.Үржинханд	Э.Отгонбаяр	
2	Монгол уран бичлэг, уран зангилаа		40	Б.Содномдаржаа	Э.Анхбаяр	
3	Ландарт, өрөг урлал	2022.10.06	40	У.Одмаа	Т.Даваасамбуу	Хун шувууны бэлэг

4	Фейшн арт		40	Б.Дөлгөөн	Д.Энхтуяа	Өвгөн эмгэн хоёр
5	Барлах урлаг, холимог технологи	2022.10.12	40	Н.Зулцэцэг	Г.Туяа	



Төвийн Уран хатгамал, Анхан шатны дугуйлангийн сурагчид “ЯРЬДАГ ФУТВОЛК 2022” футволк бүтээх уралдаанд оролцлоо.





2022 онд Монгол улсад Тахь сэргээн нутагшуулсны түүхт 30 жилийн ой тохиож байна. Ойн хүрээнд “Тахь сэргээн нутагшуулалт ба байгаль хамгаалал” гэсэн сэдвийн хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн 6-12 р ангийн хүүхдүүдийн дунд байгаль хамгаалахад иргэн бүрийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зургийн уралдаан зарласан. Хүүхдүүд Монголын говиос гаралтай тахь хэмээх зэрлэг адууны тухай өөрсдийн ойлголт, төсөөллөөр зураг болгон дүрсэлж 200 гаруй бүтээл илгээсэн байна.




2.2. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ”

2.2.1 Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд төвийн уран бүтээлч 4 багш амжилттай оролцлоо.

2.2.2 “Хамтдаа хөгжье ” Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нээлттэй өдөрлөг зохион байгуулна.

- Нийслэл хот байгуулагдсаны 383 жилийн ойн хүрээнд “Хамтдаа хөгжье” эцэг эх, олон нийтийн нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд 80 эцэг эх оролцож хүүхэдтэйгээ хамтын бүтээл туурвиж төвийн үйл ажиллагаатай танилцлаа.





Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд төвийн дугуйлангийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн дугуйлангийн сурагчдыг угтах үдэх үйлчилгээний журмын хүрээнд 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг бага насны хүүхдээ “Гараас гарт” хүлээлгэн өгч ажиллах талаар анхааруулсан санамж бичиг үйлдэн хамтран ажиллаж байна.

Дугуйлангийн сурагчдын дэг журам, аюулгүй байдлыг хангах үүднээс “Монголын хүүхдийн урлан бүтээх төвд хүүхэд суралцуулах гэрээ”-г боловсруулж эцэг, эх асран хамгаалагч нартай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.

2.3. Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна.

2.3.1. “Хүүхдэд ээлтэй Урлан” аяныг үргэлжлүүлж, хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Байгууллагынхаа гадна болон дотор орчинд хяналтын үнэлгээ хийж дотор орчинд хүүхдийг болзошгүй аюул ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд бүх давхарууд, анги танхимд галын дохиолол, камер, гэрэлтүүлгийг нэмж байршуулан ажиллаа.



Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллаж байна.



2.3.2. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна.

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдүүд болон явган зорчигчийг аюулгүй гарцаар гарах анхааруулгыг төвийн орчимд байршуулан ажиллаж байна.



- Өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол эрүүл амьдралын хэв маягт сургах сургалтын төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

2.4. Төв нь үндсэн зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана.

2.4.1 Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, халамж, асрамжийн газрын болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна.

Хүүхэд залуучууд, өсвөр үеийнхэнд урлагийн боловсрол олгох, тэдгээрийн хөгжил, соён гэгээрэл, урлаг, гоо зүйн албан ба албан бус боловсролд хувь нэмэр оруулах, мэргэжлийн солилцоог идэвхжүүлэх зорилготой олон үе шаттай “ХУН” төслийн хүрээнд ХБНГУ-ын Берлин хотын Jugendkunstschule Charlottenburg-Wilmersdorf “Хүүхэд, залуучуудын урлагийн боловсролын сургууль”-ийн хүүхдүүдийн 60 орчим бүтээлийг фото, видео хэлбэрээр дэлгэн тавьж Монгол хүүхдүүдийн хүртээл болголоо.



Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой болон “Япон, Монгол хүүхэд, залуучуудын найрамдал, солилцооны жил”-ийн хүрээнд хүүхдийн уран зургийн үзэсгэлэн, наадмыг зохион байгуулж, Нийслэл, хөдөө орон нутгийн 500 гаруй хүүхэд бүтээлээрээ оролцож шидгийн шилдэгт шалгарсан сурагч

Япон улсад Женесис хөтөлбөрт 10 хоног үнэ төлбөргүй хамрагдах эрхээр шагнагдлаа.



Монгол, Солонгос улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 32 жилийн ой, Солонгосын соёлын өдрүүдэд зориулан БНСУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын нэрэмжит 8 дахь удаагийн хүүхдийн гар урлал, уран зургийн үзэсгэлэн, наадам төвийн “Орд” арт галерейд боллоо. Тус наадамд Нийслэл болон хөдөө орон нутгийн 710 хүүхэд бүтээлээрээ оролцож шилдэг 32 сурагч, 2 багш шилдгээр шалгарлаа.



Бүгд Найрамдах Хятад Ард улсын Ниньбо хотоос зохион байгуулсан олон улсын хүүхдийн гар зургийн уралдаанд оролцож, шагналт байранд орсон дугуйлангийн сурагчид шагналаа гардан авсан.

Бүгд найрамдах Солонгос улсын Чүнчонь хотын захиргаанаас зохион байгуулсан “Хүүхдийн гар” зургийн уралдаанд шагналт байранд шалгарсан сурагчид шагналаа гардан авсан.

2.4.2 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг санаачлан зохион байгуулж, төвийн үйл ажиллагааг сурталчлан өргөжүүлнэ.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээг тогтмол хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчлан, олон нийтийн хүртээл болгож байна.

Тухайлбал, МҮОНРТ, Монгол HD, Eagle TV, TV9, SBN, LIKE TV, STAR TV, GTV, VTV, ETV, SCN TV, Үндэсний шуудан, Нийслэл сайт, Read.mn, Монголын радио, Монголын мэдээ сонин, Өдрийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна.

Бусан хотын К арт сургуулийн захирал, багш төвийн үйл ажиллагаатай танилцаж, хүүхэд хөгжлийн талаар цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцов.

2.5. Суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг сургалтын явцад анги дэвших, төгсөхөд нь дүгнэх болон сурлагын амжилтын хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлалтай байна.

Төвийн 2021-2022 оны хичээлийн жилийн тайлан үзэсгэлэн 2022 оны 05 дугаар сарын 31-нд “Орд” арт галерейд зохион байгууллаа.

Үзэсгэлэнд нийт 398 бүтээл дэлгэн тавигдлаа.

“Урлахуйн ертөнц” үзэсгэлэнгээр төвийн “Авьяасын од” алтан медалиар:

- Бага нас Б.Ичинхорлоо багштай Баримлын анхан шат - Б.Бишрэл
- Дунд нас Д.Дуламсүрэн багштай Монгол уран бичлэгийн анги - Э.Хонгорзул
- Ахлах нас С.Оюунсайхан багштай Хүүхэлдэй бэлэг дурсгалын анги - О.Мэндбилэг
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын шилдэг хүүхэд шагналаар: С.Ганцэцэг багштай Үндэсний уран хатгамал - Э.Мишээл
- Нийслэлийн шилдэг хүүхдээр:

А.Үржинханд багштай Хүүхэлдэй бэлэг дурсгалын анги - Г.Ариунзаяа

- Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газрын шагналаар:

Б.Нарангэрэл багштай Анхан шат - Э.Эмүжин нарыг тус тус шагнав.

Төвийн дугуйлангийн сурагчдаас эрдэм мэдлэг, сурлага, урлаг, спортын болон бусад төрлөөр амжилт гарган бусдыгаа манлайлсан хүүхэд багачуудаас “Дүүргийн шилдэг хүүхэд” шалгаруулах үйл ажиллагаанд тодорхойлолтыг хүргүүлж ажиллаа.


2.6. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна.

2.6.1 Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд багш, сурагчдыг дэмжиж идэвхитэй оролцуулна.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн багш нарын шилдэг бүтээлийн “ART & CRAFT-2022” 11 дэх удаагаа “ОРД” арт галерейд 2022 оны 04-р сарын 13-ний өдөр болж өнгөрлөө.

Үзэсгэлэнгийн зорилго нь: Монгол ардын уламжлалт гар урлагийг олон нийтэд сурталчлан таниулах, хүүхэд залуучуудад түгээх орчин үеийн өнгө шийдэлтэй хослуулан хэрэглэх, сурч хөгжих хүсэл эрмэлзлийг бий болгох, төвийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх юм.

Үзэсгэлэнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн уран бүтээлч багш нарын ур ухаанаар бүтсэн 80 орчим шилдэг бүтээл дэлгэгдсэн. 11 дэх удаагийн “ART & CRAFT-2022” үзэсгэлэнд Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвд ажиллаж байсан үе үеийн уран бүтээлч багш нар урилгаар оролцсон нь тухайн жилийн онцлог байлаа.





“Дэлхийн хүүхдийн өдөр”-г анх “Нэгдсэн үндэстний ерөнхий ассамблей” хүүхдийн эрхийн тунхаглалыг тэмдэглэх зорилгоор тогтоосон байдаг. Монгол орны хувьд энэ өдрийг хүүхдийн үзэл бодол дуу хоолойг сонсох тэдний эрх ашгийг хүндлэх өдөр болгон зохион байгуулдаг байна.

Энэ өдрийг тохиолдуулан Таван Богд Моторс ХХК, Geely брэнд нь Монголын хүүхдийн урлан бүтээх төвтэй хамтран тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд иргэд олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

Өдөрлөгт хүүхэд багачууд “Миний мөрөөдөл” “Миний-Монгол улс” сэдвүүдээр үзэл бодлоо илэрхийлж “Аюулгүй автомашин” сэдэвт гар зураг зуран нэгэн өдрийг хамтдаа суралцаж хөгжилтэйгөөр өнгөрүүлээ.



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.1. Төсөв, санхүүгийн чиглэлээр

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 851.602.8 сая төгрөгний санхүүжилтээс 696.012.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр аудитаас зөрчилгүй санал дүгнэлтийг авч өглөг авлагагүй ажиллаж байна. ЗГ-ын 64 дүгээр тогтоолын биелэлтийг хангаж төсвийг 12 дугаар сарын 15-ны байдлаар төгрөгөөр хэмнэж ажиллаа. Үлдэгдэл сая төгрөгийг санхүү төрийн санд төвлөрүүлж ажиллаа. Хуулиар тогтоосон хугацаанд <https://shilendans.gov.mn/org/4315> сайтад мэдээллийг тогтмол байршуулж мөн <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

3.1.2. Үндсэн хөрөнгө бүртгэл, дэд системийн ашиглалтыг бүрэн хариуцаж ажиллах

Ашиглалтыг сайжруулан ажиллаж байна.

3.1.3 Батлагдсан төсвийн хүрээнд гурвалсан гэрээний үүргээр болон заалны түрээсийн орлогоор төсөвт 12.300.0 төгрөгний орлого төвлөрүүлэхээс 9.623.4 сая төгрөгний орлого төвлөрүүлсэн.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

3.2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх

3.3. Архив, албан хэрэг, хөтлөлтийн чиглэлээр:

3.3.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангаж, “UB.ERP” системийн Edoc, Өргөдөл гомдол, Тайлан судалгаа, дэд системүүдийн ашиглалтыг бүрэн хангаж ажиллах

Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллаа.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захиргааны 13 албан хаагч www.edoc.ulaanbaatar.mn программыг ашиглаж, 35 багш, албан хаагчид www.erp.ulaanbaatar.mn программыг ашиглаж түүний хэрэгжилтэд хүний нөөцийн асуудал хариуцсан мргэжилтэн хяналт тавин ажиллаж байна.

2022 оны байдлаар:

	Албан бичиг	Нийт тоо	Үүнээс:	Шийдвэрлэлт
1	Ирсэн бичиг	160	57 хариутай	98.62%
			103 хариугүй	
2	Явсан бичиг	79	... хариугүй	100%

3.3.2. Архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, зааврын дагуу хөтлөн явуулах Захирлын А, Б тушаалуудыг нөхөн бүрдүүлэлтээр цахим хуудааст оруулж, байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

3.4. Ил тод байдлын чиглэлээр:

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй байлгаж, байгууллагын мэдээллийн самбын мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна.

3.5. Хүний нөөцийн чиглэлээр:

3.5.1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах

Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 11 ажил үйлчилгээ төлөвлөж биелэлтийг ханган ажиллаа.

Хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон харьяа хэлтэс албадаас зохион байгуулсан Төрийн албан хаагчын ёс зүй сэдэвт сургалт, Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан сургалт, Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ үнэлгээ сэдэвт сургалт, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай сургалт, Хүний нөөцийн чуулган зэрэгт албан хаагчдыг тухай бүр хамруулж ажиллаа.

Төвийн багш, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, зорилгоор “Багш хөгжил” лекц цуврал сургалтыг 6 удаа, дотоодын цахим сургалт 2 удаа, танхимын сургалт 3 удаа зохион байгуулсан болно.

Мөн албан хаагчдад “Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд” “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг СНА-ны нийгэмлэгийн тэргүүн Д.Мөнхжаргалыг урьж сургалт зохион байгуулсан.

Албан хаагчид мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр:

№	Хамрагдсан сургалт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	Хугацаа
1	Дүрслэх урлагийн академи – Уран зургийн чиглэлээр бакалавр зэрэг	Ц.Дуламсүрэн-Анхан шатны багш	2019-2023
2	Англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт	Т.Даваасамбуу – Уран баримлын дугуйлангийн багш	2022-2023

3.5.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах

Цалин хөлс, шагнал, урамшууллын чиглэлээр:

Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан ажлын үр дүнд үндэслэн зохих нэмэгдлүүдийг хоол унааны зардлын хамт тогтмол олгож байна.

Төвийн албан хаагчдаас улсад болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хамт олноо ажил үйлсээрээ манлайлж ажиллаж байгаа

шилдэг, тэргүүний, ахмад багш, албан хаачдыг төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагналд тодорхойлж шагнаж урамшуулсан.

Үүнд: Хийц бэлтгэгч Х.Бямбадорж, Жижүүр Ш.Хишигбуян нар Монгол Улсын төрийн дээд одон Алтангадас одонгоор, Нягтлан бодогч Х.Отгонбаяр , Сүрлэн сүлжмэлийн багш Г.Туяа нар төрийн дээд медаль Хөдөлмөрийн хүндэт медалиар, Анхан шатны дугуйлангийн багш Ц.Дуламсүрэн БШУЯамны шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Анхан шатны багш Б.Булгантуяа ХНХЯ-ны “Жуух бичиг”-ээр, Үйлчлэгч С.Болормаа НХГБЗ-ын газрын Шилдэг залуу тэмдгээр тус тус шагнагдсан.



Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлыг арилгах зорилгоор Илүүдэл жингүй –Эртэч Монгол” аянд нэгдэж хөгжимт дасгал, иог хийж идэвхтэй хамрагдаж ажиллаа.





Албан хаагчид ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлж байна.



Байгууллагын ахмад настангууддаа мэндчилгээ гарын бэлгийг гардуулан өгсөн



Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран ажиллаж албан хаагчдаа хэсэгчилэн эрт илрүүлэгт хамруулж ажиллаа



Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлыг арилгах зорилгоор Спорт өдөрлөгийг зохио байгууллаа.



Ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ажлын байр ажлын хүрээнд “Эрүүл хоолны өдөрлөг”-ийг сар бүр 2 удаа зохион байгуулан ажиллаж байна.

Тус өдөрлөгийг зохион байгуулснаар Албан хаагчид эрүүл хооллолтын талаар мэдлэг хандлагатай болж байна.

Төвийн албан хаагчдыг ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр байгууллагаас олгох зохих тэтгэмж, урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Үүнд: 2022 оны байгууллагаас тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 29.239.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон..

Хамт олны фондноос эмнэлэгт хэвтэх, хагалгаанд орох, хүүхэд төрүүлэх, гэр бүлийн хүмүүсээс нь нас барсан зэрэг гачигдал гарсан албан хаагчдад нийт 1,733,000 төгрөгний тусламж үзүүлж ажилласан.

ДҮГНЭЛТ

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв нь 2022-2023 оны хичээлийн жилд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” эрхэм зорилго дэвшүүлэн хүүхэд багачуудын хэрэгцээ хүсэл сонирхолд нийцүүлэн Уран зургийн дугуйлангийн ангийг төрөлжүүлэн нэмж 18 төрлийн 20 дугуйланд нийт 2100 хүүхдийг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр үнэ төлбөргүй сурган хөгжүүлж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын батлагдсан төсвийг зүй зохистой зарцуулан, төсвийн хэмнэлт гаргаж өр төлбөргүй ажиллаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН _____ /Л.АТАР/

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ _____ /Д.УРАНБИЛЭГ/